

## Автобус, такси бааз

1929-11-31-энд Монголтрансын ерөнхий хорооны 6 дугаар хурлаас Улаанбаатар хотод Амгалан-баатар хотын төвийн хооронд автобус явуулахаар тогтоон үйлчилгээг нээж 2 буудалд , өдөртөө 5 удаа 2 машин явуулж эхэлжээ.

1933 онд өртөө шуудан буудлын харьяанд Улаанбаатар хотын автобусны гараашийг 11 автобустайгаар байгуулжээ.

1936 онд 14 автобусны 2-ыг Улаанбаатар, Улаан-үдийн замд 12-ийг Улаанбаатар хотод явуулж, 1937 онд 98.3 мянган зорчигч тээвэрлэж, 14.0 сая хүн км гүйцэтгэж байсан бол 1940 онд 872 мянган зорчигч тээвэрлэж, 215 сая хүн км-ийн үүрэг гүйцэтгэжээ.

1969 оны 5 дугаар сард Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Улаанбаатар хотын автобус баазад албан үйлдвэрийн газар, байгууллагуудын автобусаар төрөлжсөн журмаар үйлчлэх тусгай хэсэг байгуулах. Такси баазад чиглэлийн ба дуудлагын ачааны таксийг байнгын үйлчилгээ бий болгох. - Автобус, таксийг 1970 оноос хоёр ээлжийн жолоочтой болгон ажиллуулах. - Жолооч, кондуктор, инженер техникийн ажилтанд олгох шагналын журам тогтоон мөрдүүлэх арга хэмжээ авчээ.

1959-8-12-энд сайд нарын Зөвлөлийн 332 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын автобус, такси, моторын баазыг автобусны бааз, такси бааз болгон салгаж аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахаар тогтоожээ.

1970 оноос төлөвлөлт, эдийн засгийн урамшлын шинэ системийг туршлагын журмаар нэвтрүүлэн ажилласан.

1970-2-20-онд сайд нарын Зөвлөлийн 36 дугаар тогтоолоор 1970 онд автобус, такси баазуудын аж ахуй, төлөвлөлт, эдийн засгийн урамшууллын арга хэлбэрийг өөрчлөн туршихаар тогтоожээ.

Төлөвлөлт, урамшууллын шинэ системийг туршлагын журмаар нэвтрүүлснээр 1960 оноос 1974 онд автобусны үйлчлэх чиглэл 2 дахин, автобусны тоо 6 дахин , таксин тоо 7.5 хувиар нэмэгдэж хотын 1 хүн 1960 онд жилд дунджаар 73.4 удаа зорчиж байсан бол 1970 онд 165 удаа, 1974 онд 200 гаруй удаа зорчих болж нэмэгдсэн байна.